



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2012 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН СТАТИСТИК
ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАНИЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ
2012.11.28**

А. МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2012 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОЙМ

Зах зээлийн үнэлгээ:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээг тооцоход 1,660,643,529,560.0 төгрөг болсон нь өмнөх жилийн эцсийн дүнгээс даруй 507,926,454,639.00 төгрөгөөр буюу 23.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2011 оны байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2 их наяд 168 тэрбум 569 сая 984 мянга 199 төгрөгт хүрч байсан нь өмнөх он буюу 2010 оны мөн үеийнхээс 794.6 тэрбум төгрөгөөр буюу 57.8 хувиар өссөн үзүүлэлттэй байв. 2011 онд уул уурхайн салбарын томоохон компаниуд хувьцаагаа олон улсын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргасан нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын хөрөнгийн зах зээл зүй ёсоор татаж, нэгж үнэт цаасны үнэд эерэг нөлөөлснөөр тайлант хугацааны зах зээлийн үнэлгээ өсч байжээ.

Зах зээлийн өндөр үнэлгээтэй компаниудыг “Таван толгой” ХК /579.3 тэрбум/, “АПУ” ХК /312 тэрбум/, “Багануур” ХК /274.8 тэрбум/, “Шивээ овоо” ХК /205.3 тэрбум/, “Шарын гол” ХК /96.7 тэрбум/ зэрэг хувьцаат компани тэргүүлж байна.


Зах зээлийн үнэлгээ

Хүснэгт-1

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2009
Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	131,000,000,000	717,560,948,996.00	515,872,401,400.00	620,705,716,456.0
Үзүүлэлтүүд	2010	2011	2012.10.31	
Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	1,373,946,157,039.0	2,168,569,984,199.00	1,660,643,529,560.0	

Дээрх хүснэгтэд үзүүлснээр зах зээлийн үнэлгээний дүн буурахад “Монголын хөрөнгийн бирж” ХК-д үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хяналтын “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан хийгдэж буй арилжааны дараахь үеийн буюу төлбөр тооцооны эрсдлийг бууруулах шинэчлэлийн ажлууд, тэр дундаа шинэ системээс биржийн гишүүн брокер, дилерийн компани болон хөрөнгө оруулагч, харилцагчдад тавигдах нөхцлийг хангах хэрэгжүүлэх ажил удааширсан, мөн 2012 онд гадаад эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаа, сонгуулийн жил тохиосон зэрэг нь дээрх үзүүлэлтийг бууруулах нөлөө үзүүлсэн гэж үзэхээр байна.

График-1



2012 оны эхний 10 сарын байдлаар зах зээлийн үнэлгээний ерөнхий трэнд болох харьцааны үзүүлэлтүүд 2012 оны 2 дугаар сараас эхлэн буурсан хандлагатай байна.

2012 оны 3 улирлын дотоодын нийт бүтээгдхүүний дүнд 2012 оны 10 дугаар сарын 31-ны өдрөөр тооцогдсон зах зээлийн үнэлгээг харьцуулахад 16.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны жилийн эцсийн хувиас 3.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2011 оны жилийн эцсийн зах зээлийн үнэлгээний дүн 2168.5 их наяд төгрөг байсан нь мөн оны дотоод нийт бүтээгдэхүүний дүнд харьцуулахад даруй 20 хувийг эзэлж байжээ.

Графикаас үзэхэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээний өсөлт нь Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн буюу макро эдийн засгийн нийт гарцын өсөлттэй шууд хамааралтай үзүүлэлт болох нь харагдаж байна.

График-2



Үнэт цаасны арилжаа:


2006 оноос гадаадын иргэд, хуулийн этгээдээс Монгол улсад шууд болон шууд бусаар хөрөнгө оруулах сонирхол идэвхжиж, тэдгээрийн оролцоо огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор Хөрөнгийн биржид арилжаалагдаж буй хувьцаат компаниудын үнэт цаасны үнэ, ханшид өсөх хандлага бий болсон.

2011 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр нийт 252 өдрийн арилжаа хийгдсэн бөгөөд нийт 148 хувьцаат компанийн 122.8 сая ширхэг хувьцаа 109.1 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын 2.4 сая ширхэг бонд 236.7 тэрбум төгрөгөөр, компанийн 439.5 мянган ширхэг бонд 4.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагджээ.

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр нийт 210 өдрийн арилжаагаар 143.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 131.5 сая ширхэг хувьцаа, 309.7 сая төгрөгийн үнэтэй 30.9 мянган ширхэг компанийн бонд, 525.0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг Засгийн газрын бонд тус тус арилжаалагдав.

Хувьцааны арилжааны дүн болох 143.2 тэрбум төгрөгийг өмнөх оны жилийн эцсийн дүнд харьцуулахад 34.1 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч нийт арилжааны 88 хувийг буюу 125.9 тэрбум төгрөгийг багцын арилжаа дангаараа эзэлсэн байна.

График-3




Засгийн газрын болон компанийн бондын арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл:

2006 оноос “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр Засгийн газрын болон компанийн бондын арилжаа идэвхитэй явагдаж, хөрөнгийн зах зээлээс нийтдээ 341,3 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна. Ялангуяа 2010, 2011 ондуудад төрөөс томоохон хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үүднээс “Монголын хөрөнгийн бирж” дээр Засгийн газрын бондыг арилжиж, нийт 30.0, 236.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг тус тус татжээ.

Мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган, шинэ хямд эх үүсвэр татах замаар ипотекийн анхдагч зах зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбох, улмаар зээлийн хүүг бууруулж, хүн амын орон сууцны хэрэгцээг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2.5, 3.5, 5 жилийн хугацаатай, жилийн 14.0, 14.3, 14.5 хувийн хүүтэй 3 төрлийн нөхцөл бүхий нэг бүр нь 1,000,000 /Нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 25,000 /Хорин таван мянга/ ширхэг “МИК” бондыг зах зээлд гаргасан байна.

Бондын арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/



Засгийн газрын бондын арилжааны мэдээлэл

Хүснэгт-2

Он	Арилжаа явагдсан өдрийн тоо	Арилжигдсан бондын тоо (мян.ш)		Үнийн дүн (сая төг)		Хөрөнгө оруулагчид (сая төг)			
		Нийт	Өдрийн дундаж	Нийт	Өдрийн дундаж	Арилжааны банкууд	Бизнесийн байгууллагууд	Төрийн байгууллагууд	Хувь хүмүүс
2004	3	130.0	43.3	12463.8	4154.6	12463.8	-	-	-
2005	1	70.0	70.0	6767.0	6767.7	6767.7	-	-	-
2006	2	47.0	23.5	4461.5	2230.8	4461.5	-	-	-
2007	10	408.6	40.9	39599.28	3959.9	39539.3	59.3	-	0.8
2008	4	16.06	4.015	1494.736	373.7	1213.4	279.3	-	2.0
2009	-	-	-	-	-	-	-	-	-
2010	1	3.0	3.0	30000.0	30000.0	17500.0	-	12500.0	-
2011	14	2367.306	169.1	236730.6	16909.3	236219.5	409.1	-	102

Компанийн бондын арилжааны мэдээлэл

Хүснэгт-3

Арилжаа явагдсан	Арилжигдсан бондын тоо (мян.ш)	Үнийн дүн (сая төг)	Хөрөнгө оруулагчид (сая төг)

Он		Нийт	Өдрийн дундаж	Нийт	Өдрийн дундаж	Арилжааны банкууд	Бизнесийн байгууллагууд	Хувь хүмүүс
2008	1	50.2	50.2	502	502	502	-	-
2009	-	-	-	-	-	-	-	-
2010	-	-	-	-	-	-	-	-
2011	14	439.5	31.4	4394.5	313.8	2000	-	2394.54

Хүснэгтээс харахад, Засгийн газрын бондын дийлэнх хувийг цөөн тооны арилжааны банкууд худалдан авч, эрсдэлгүй өгөөж өндөртэй хөрөнгөөр өөрийн активыг идэвхтэй бүрдүүлж байв. Энэ нь Монголбанкны зүгээс сүүлийн жилүүдэд мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой гэж үзэхээр байна.

Засгийн газрын болон компанийн бондын бүртгэлийн мэдээлэл:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “ҮЦТТТХТ” ХХК-д хадгалагдаж буй компанийн болон Засгийн газрын бондын судлагааг хүснэгтээр үзүүлбэл дараахь байдалтай байна.

Биржид бүртгэлтэй бонд

Хүснэгт-4

Д/Д	Биржийн зах зээлд бүртгэлтэй	Тоо ширхэг	Үнийн дүн /төгрөгөөр/
1.	Компанийн бонд /нийт таван компанийн/	672,918	3,367,196,000.0
2.	Засгийн газрын бонд /наян төрлийн/	4,044,870	404,329,950,000.0

Биржид бүртгэлгүй бонд

Хүснэгт-5

Д/Д	Биржийн бус зах зээлд бүртгэлтэй	Тоо ширхэг	Үнийн дүн /төгрөгөөр/
1.	Монголын ипотекийн корпорацийн /зургаан төрлийн/	20,917	21,185,000,000.0
2.	Засгийн газрын бонд /хоёр төрлийн/	1,000,000	100,000,000,000.0

Засгийн газрын болон компанийн бондын төлбөрийн мэдээлэл:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “ҮЦТТТХТ” ХХК-д хадгалагдаж буй компанийн болон Засгийн газрын бондын төлбөрийн судлагааг хүснэгтээр үзүүлбэл дараахь байдалтай байна.

Бондын үндсэн болон хүүгийн төлбөр

Хүснэгт-6

Д/Д	Бондын төрөл	Төлбөл зохих үндсэн болон хүүгийн төлбөр /төгрөг/	Төлөгдсөн үндсэн болон хүүгийн төлбөр /төгрөг/	Төлөгдөөгүй үлдэгдэл /төгрөг/
1.	Засгийн газрын бонд	Үндсэн төлбөр 236,730,600,000.0 хүүгийн төлбөр	Үндсэн төлбөр 91,975,000,000.0 хүүгийн төлбөр	Үндсэн төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл 144,755,600,000.0

		34,992,568,645.37	16,116,289,466.51	
2.	Монголын ипотекийн корпораци ХХК-ийн бонд	Үндсэн төлбөр 6,300,000,000.0 хүүгийн төлбөр 2,071,768,614.67	Үндсэн төлбөр 4,083,000,000.0 хүүгийн төлбөр 1,678,641,482.0	Үндсэн төлбөр 2,217,000,000.0, хүүгийн төлбөр 393,127,132.67

Монгол банкны ерөнхийлөгч болон Сангийн сайдын 2012 оны 217/А-161 тоот хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах тухай журам”-ыг баталсан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн заалтуудыг зөрчсөн, хөрөнгийн зах зээлийн хэтийн хөгжлийг сааруулсан, бондын анхдагч зах зээлийн арилжаанаас хувь хүн, хуулийн этгээд худалдан авч үр шимийг нь хүртгэх боломжийг хязгаарлаж, зөвхөн банкны салбарыг дэмжсэн өрөөсгөл зохицуулалт гэж үзэхээр байгаа тул бондын хоёрдогч зах зээлийг Хөрөнгийн бирж дээр зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаа Монголын хөрөнгийн бирж дээр өмнө нь хийгдэж байгаагүй бөгөөд 2012 онд 5 ширхэг Засгийн газрын бондыг 525.0 мянган төгрөгөөр туршилтын журмаар арилжсан нь хоёрдогч зах зээлд арилжаалагдсан анхны арилжаа болжээ.

Үнэт цаасны индекс:


2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ТОП-20 индекс 16,059.99 нэгжид хүрсэн бөгөөд өмнөх оны жилийн эцсийн дүнгээс даруй 5,627.58 нэгжээр буурчээ. Мөн сард ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 17,709.4 нэгж, доод үзүүлэлт 16,059.99 нэгж, дундаж үзүүлэлт 16,840.7 нэгж байв.

2011 оны жилийн эцсийн дүнгээр хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлдэг ТОП-20 индекс 21,687.57 нэгж байсан нь 2010 оны мөн үетэй харьцуулахад 6,927.76 нэгжээр буюу 46.9 хувиар өссөн үзүүлэлттэй байсан бөгөөд тус индексийн дээд үзүүлэлт 32954.97 нэгж, доод үзүүлэлт 14686.64 нэгж, дундаж үзүүлэлт 21420.81 нэгж байв.

ТОП-20 индексийн өсөлт, бууралтад макро болон микро эдийн засгийн үзүүлэлтүүд болох инфляци, гадаад валютын ханш, мөнгөний бодлого, хувьцаат компанийн санхүүгийн чадвар болон хөрөнгө оруулагчдын шийдвэр зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн нь тодорхой билээ.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаа цөөхөн тооны хувь хүмүүс дээр төвлөрсөн нь эргээд зах зээлийн арилжааны идэвхийг сааруулж, хөрвөх чадварыг бууруулах нөлөө үзүүлж байна. Төвлөрөл өндөр, хөрвөх чадвар багатай байгаа нь ТОП-20 индексийн үзүүлэлтийг хэлбэлзүүлэх эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид хэлбэлзэл өндөртэй индекст тулгуурлан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах нь өөрөө эрсдлийг дагуулдаг гэж үздэг тул цаашид ТОП-20 индексийн савлагааг багасгасан, салбаруудын онцлогыг тодорхойлж чадахуйц аж ахуйн нэгжүүдээр индексийг сагсыг бүрдүүлэн тооцох аргачлалыг тухай бүр хэрэгжүүлэх шаардлагатай.


Энэ утгаараа хөрөнгийн биржийн зүгээс хөрөнгө оруулагч, иргэдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нөлөө үзүүлэгч хувьсагч үзүүлэлтүүд болох хувьцаат компаниудын β коэффициентыг тооцон нийтэд мэдээлэх зүйтэй болов уу.



Хөрөнгийн бирж дээр хийгдсэн хэлцэл:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр өссөн дүнгээр нийт 24.5 мянган хэлцэл хийгдсэн байна. Оны эхнээс Хөрөнгийн бирж дээр хийгдэж буй хэлцлийн тоо буурсан бөгөөд өнгөрсөн 7 дугаар сард хамгийн бага буюу 155 ширхэг хэлцэл хийгдсэн боловч 8-10 саруудад бага зэргийн өсөлт ажиглагдаж байна. Хэлцлийн тоо буурсан шалтгааныг “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлж, арилжааны болон арилжааны дараахь үе шатны үйлдлийн функцийг туршилт, түүнийг нэвтрүүлэх явцад гарсан алдааг засах, тохируулах зэрэг шинэчлэлийн үйл ажиллагаа хийгдэж байсантай холбон үзэхээр байна. Мөн брокерийн компаниуд дээр ашиглагдах бак офис буюу мэдээллийн нэгдсэн сүлжээний тогтолцоо сонгодог утгаараа хэрэгжээгүй ба эерэг тохиолдолд хэлцлийн биелэгдэх хугацаа, тоо хэмжээнд бодитой өөрчлөлт гарах магадлалтай. Зах зээлд төлбөр гүйцэтгэгч банк, мэргэжлийн оролцогч байгууллагууд хоорондын мэдээллийн нэгдсэн тогтолцоо үгүй аваас цаашид хөрөнгө оруулагчдын идэвх сэргэж, бирж дээрх хэлцлийн хэмжээ ихэссэн тохиолдолд цаг хугацаа алдах, цаашлаад системд сөрөг нөлөөтэй.

График-6



Анхдагч зах зээлийн мэдээлэл:

2005-2012 онуудын хооронд нийт 17 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасаа бүртгүүлэн шинээр болон нэмж үнэт цаас гаргаад байгаа бөгөөд дээрх компаниудын хувьцааны арилжаа нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт арилжааны 23.4 хувийг эзэлж байна. Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан хувьцааны бүтцийг авч үзвэл 53 хувь нь олборлох болон боловсруулах салбарын аж ахуй нэгжүүд байна. Үүнээс үзэхэд, аж үйлдвэрлэлийн олборлох болон боловсруулах салбарын аж ахуй нэгжүүд хөрөнгийн зах зээлээс санхүүгийн эх үүсвэр татаж, түүгээрээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөөц бололцоо буйг харуулж байна.

2011 онд анхдагч зах зээлийн арилжаагаар “Шарын гол” ХК-ийн нэмж гаргасан 1,6 сая ширхэг хувьцаа 18,3 тэрбум төгрөгөөр, “Силикат” ХК-ийн нэмж гаргасан 16,2 сая ширхэг хувьцаа 3,6 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагджээ.

2012 онд анхдагч зах зээл дээр “Эйр транс ложистик” ХК-ийн 7.7 сая ширхэг энгийн хувьцаа арилжаалагдаж, нийт 924 сая төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн байна. Мөн “Монгол шуудан” ХК анхдагч зах зээл дээр үнэт цаасаа арилжаалах зөвшөөрлийг Хорооноос аваад байна.

График - 7

IPO, SPO хийсэн компанийн эдийн засгийн бүтцийг хувиар үзүүлбэл



Анхдагч зах зээлд үнэт цаасаа арилжаалсан компанийн тоо, татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн

Хүснэгт-7

д/д	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	Зоос банк	Банк санхүү	1,999,768.00	2,022,528,900.00
2	Монгол шилтгээн	Зочид буудал	1,000,000.00	800,000,000.00
3	БиДиСек	Санхүүгийн зуучлал	8,400,014.00	3,375,346,500.00
4	Оллоо	Мэдээлэл технологи	5,820,299.00	582,029,900.00
5	Хай Би Ойл	Тос тосолгооны маиериал үйлдвэрлэл	6,738,361.00	1,128,474,814.00
6	Монинжбар	Барилга угсралт	10,000,000.00	1,000,000,000.00
7	Женко тур бюро	Аялал зуучлал	78,895,885.00	8,259,239,676.00
8	Туул сонгино усны нөөц	Хөрөнгө оруулалт дэд бүтэц	13,200,000.00	13,200,061,250.00
9	Гермесцентр	Худалдаа үйлчилгээ	23,562,900.00	2,356,290,000.00
10	Анод банк	Банк санхүү	18,618,171.00	20,107,624,680.00
11	Ремикон	Барилгын материал үйлдвэрлэл	50,488,202.00	5,048,820,200.00

12	Хөх ган	Ган төмөр үйлдвэрлэл	30,395,272.00	3,195,456,280.00
13	Монфреш шүүс	Ундаа усны үйлдвэрлэл	692,432.00	69,243,200.00
14	Нако түлш	Түлш үйлдвэрлэл	1,180,195.00	270,264,655.00
15	Силикат	Барилгын материал үйлдвэрлэл	16,222,300.00	3,650,017,500.00
16	Шарын гол	Уул уурхай	1,646,257.00	18,301,439,069.00
17	Э транс ложистикс	Тээвэр	7,700,000.00	924,000,000.00
	Нийт дүн		276,560,056.00	84,290,836,624.00

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 94, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 18 компани байна.


Одоогийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нийт 79 компани гишүүнчлэлээр элссэн бөгөөд үүнээс 47 брокер, дилерийн компани биржийн арилжаанд оролцох шаардлагыг хангаж, арилжаанд оролцох эрхтэй болоод байна. Миллениум Ай Ти арилжааны системийг “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр нэвтрүүлснээс хойш буюу 2012.07.02-ноос 2012.10.29-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 83 удаагийн арилжаагаар 2669 удаагийн арилжааны хэлцэл хийгдсэн байх бөгөөд нийт 83 хувьцаат компанийн 23.3 сая ширхэг үнэт цаасыг 82.3 тэрбум төгрөгөөр арилжаалагджээ.

2012 он гарсаар Хорооноос 9 аж ахуйн нэгжид брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ. Мөн 5 компанид нэмэлт тусгай зөвшөөрөл, 2 компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 компанийн тусгай зөвшөөрлийг сэргээх, 14 компанийн тусгай зөвшөөрлийг сунгах, 2 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэр гарсан байна.

Энэ хугацаанд нийт 17 компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд оруулах өөрчлөлт, 11 компанийн захирлыг шинээр томилох мөн 1 компанийн оноосон нэрийг өөрчлөх, 2 компанид орон нутагт салбар нээн ажиллуулах талаар Хорооны даргын тушаал гарчээ.

График-8

Мэргэжлийн оролцогчийн судалгаа




Ногдол ашгийн мэдээлэл:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 29 хувьцаат компани 79.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргаад байна. Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилсан ногдол ашгийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна. Хэдийгээр ногдол ашиг өгч буй компаниудын тоо харилцан адилгүй байгаа ч нийт тараагдаж буй ногдол ашгийн мөнгөн дүн, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ тогтмол нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График-9

Ногдол ашиг тараалт /2001-2012/



2012 онд ногдол ашиг тараасан компанийн тоо

Хүснэгт -8

д/д	КОМПАНИЙН НЭР	КОД	САЛБАР	ХАРЬЯАЛАЛ	НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ /ТӨГ/	НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО ШИРХЭГ	НОГДОЛ АШГИЙН НИЙТ ДҮН /ТӨГ/	ТАРААХ ХЭЛБЭР
1	Ремикон	530	В	УБ	5	78,679,464	393,397,320	ҮЦТТТХТ
2	АПУ	90	В	УБ	60	74,287,700	4,457,262,000	ҮЦТТТХТ
3	Махимпекс	208	В	УБ	60	3,800,721	228,043,260	ХК
4	Эрдэнэт суврага	377	D	БУ	5	35,591	177,955	ҮЦТТТХТ
5	Талх чихэр	22	В	УБ	90	1,023,703	92,133,270	ХК
6	Ган хийц	234	А	УБ	150	242,464	36,369,600	ҮЦТТТХТ
7	Тахь-ко	44	В	УБ	56	1,189,983	66,639,048	ҮЦТТТХТ
8	Адуунчулуун	461	А	ДО	45	3,151,304	141,808,680	ҮЦТТТХТ
9	Хялганат	114	А	ОР	148.32	10,113	1,499,960	ҮЦТТТХТ
10	Улаанбаатар ЗБ	3	Е	УБ	300	335,297	100,589,100	ҮЦТТТХТ
11	Баянгол ЗБ	13	Е	УБ	350	423,065	148,072,750	ҮЦТТТХТ
12	Дорнод худалдаа	311	Е	ДО	50	73,969	3,698,450	ҮЦТТТХТ
13	Монинжбар	25	D	УБ	2	15,869,233	31,738,466	ҮЦТТТХТ
14	Байгууламж	24	D	УБ	200	50,922	10,184,400	ҮЦТТТХТ

15	Тулга	5	Е	УБ	60	131,620	7,897,200	ҮЦТТХТ
16	Ээрмэл	191	С	УБ	31.74	3,479,320	110,433,617	ҮЦТТХТ
17	Таван толгой	458	А	ӨМ	1368	52,665,200	72,045,993,600	ҮЦТТХТ
18	Женко тур бюро	521	Е	УБ	1.5	100,000,000	150,000,000	ҮЦТТХТ
19	Хүрд	8	D	УБ	138	135,266	18,666,708	ХК
20	Талын гал	464	А	СБ	10	694,264	6,942,640	ҮЦТТХТ
21	Могойн гол	444	А	ХӨ	5	829,622	4,148,110	ҮЦТТХТ
22	Тээвэр дархан	217	D	ДА	400	163,349	65,339,600	ҮЦТТХТ
23	Монгол алт	68	А	ДА	150	265,852	39,877,800	ҮЦТТХТ
24	Газар сүлжмэл	34	B	УБ	2835.63	65,362	185,342,448	ҮЦТТХТ
25	Гутал	88	B	УБ	120	1,618,684	194,242,080	ХК
26	Говь	354	B	УБ	100	780,113	78,011,250	ХК ҮЦТТХТ
27	Зоос гоёл	450	B	УБ	18	3,754,944	67,588,992	ХК
28	Материал импекс	379	Е	УБ	50	1,368,206	68,410,300	ҮЦТТХТ
29	"МЦХ" ХК	209	Е	УБ	13.28	25,870,276	343,557,265	ҮЦТТХТ
Нэгдсэн дүн						370,995,607	79,098,065,869	

Бүртгэлтэй хувьцаат компани:

2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 330 хувьцаат компани Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэйгээс төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой 55, хувийн өмчийн 275 компани үйл ажиллагаа явуулж байна. 2012 онд нийт 159 компани хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлаа хийж, хурлын материалаа Хороонд ирүүлсэн бол 3 компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэрийг Хорооноос гаргасан байна.

Хүснэгт -9

Үзүүлэлт	2006	2007	2008	2009
Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	387	384	376	358
Үзүүлэлт	2010	2011	2012.10.31	
Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	336	330	330	

Төлбөр тооцоо, хадгаламжийн үзүүлэлтүүд:

2012 оны эхний 3 улирлын байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар нийт 2057 харилцагчийн дансанд 6483 удаагийн 229.1 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ, нийт 6238 харилцагчийн 8788 удаагийн 203.9 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус гүйцэтгэжээ.

Үүнээс 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдөр буюу шинэ системд шилжиж орсноос хойш 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжааны 1.42 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн гүйлгээг төлбөр тооцоо гүйцэтгэх банк хооронд хийж гүйцэтгэснээс “Голомт” банкаар 1.03 тэрбум төгрөг, “Хаан” банкаар 54.6 сая төгрөг, “Хас” банкаар 256.5 сая төгрөг, “Худалдаа хөгжлийн” банкаар 74.6 сая төгрөгийн үнэт цаасны арилжааны төлбөрийг тус тус гүйцэтгэсэн байна.

Одоогийн байдлаар нийт 47 брокер, дилерийн компани 522.9 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг өөрийн харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны тусгай дансанд, нийт 56 брокер, дилерийн компани 286.2 сая төгрөгийг “ҮЦТТТХТ” ХХК-ийн төлбөрийн баталгааны санд тус тус байршуулаад байна.

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19.2.11, “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.1.3-д заасны дагуу брокер, дилер, андеррайтерийн компаниудаас тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсан эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг “ҮЦТТТХТ” ХХК-ийн тусгайлсан дансанд байршуулдаг бөгөөд уг санд нийтдээ 628,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байршиж байна.

Үүнээс үзэхэд “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр шинэ систем нэвтрүүлэх, Т+3 буюу үнэт цаасны төлбөр тооцооны шинэ горимд шилжих бэлтгэл ажлын хүрээнд дээрх сангуудад одоогийн байдлаар дээрх 3 санд нийт 1 тэрбум 438 сая төгрөгийг эрсдлийг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас татан төвлөрүүлж хөдөлгөөнгүй түгжсэнээр энэ нь тэдгээрт уг мөнгөөр төлбөрөө барагдуулах, үнэт цаасны арилжаанд оролцож ашиг олох, хөрвөх чадварыг сайжруулах боломжийг хааж, санхүүгийн дарамт учруулсан, үүнээс үүдэн тодорхой хэмжээгээр мэргэжлийн оролцогчдын санхүүгийн байдал доройтсоноор тэдгээрийн болон цаашлаад үнэт цаасны зах зээлийн нэр хүнд нэгэнт унасан байх тул дээрх татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн ачааллаас тодорхой хэмжээгээр хөнгөлөх, дэмжлэг үзүүлэх шаардлагатай болжээ.

Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаасны төрөл

Хүснэгт-10

Үзүүлэлт	2010	2011	2012.III
Төрийн мэдлийн бус хувьцаа	1,034,875.0	2,555,045.0	2,661,644.0
Төрийн мэдлийн хувьцаа	1,883,029.0	15,356,933.0	15,503,408.0
Орон нутгийн оролцоотой компани	-	29,128.0	29,046.0
Нийт хувьцааны дүн	2,917,904.0	17,941,105.0	18,194,098.0
Засгийн газрын хямдруулсан бонд	3.0	4,238.0	4,235.0
Компанийн бонд	592.9	3,233.0	672.9
Нийт бондын дүн	596.0	7,471.0	4,908.0

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлсэнээс хойш буюу 1995 оноос 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд төвлөрсөн хадгаламжинд шинээр 315,628.0, ХОЭБ-ээр 447,800.0, холболт данс 128,574.0 буюу нийт 763,428.0 данс нээгдсэн байна. Харилцагчийн төрлөөр тооцвол Монгол иргэний 759,414, Гадаадын иргэний 1,597, Монгол аж ахуйн нэгжийн 2,270, Гадаадын аж ахуйн нэгжийн 147 дансыг тус тус нээсэн байна.

Төвлөрсөн хадгаламжид данс нээлгэсэн харилцагчийг төрөл

Хүснэгт-11

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012/10/31
Холболтын данс	2,202	4,449	3,512	1,086	3,528	14,660	8,088
ХОЭБ-ийн данс	20,579	20,579	19,077	8,240	4,846	5,569	95,278
Шинэ данс	2,304	50,221	2,654	671	1,310	108,909	103,416

Нийт данс	25,085	75,249	25,243	9,997	9,684	129,138	206,782
------------------	--------	--------	--------	-------	-------	---------	---------

Биржийн бус гүйлгээ: 2012 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 177 хувьцаат компанийн 43,924.0 ширхэг хувьцааг өв залгамжлал болон бэлэглэлээр шилжүүлсэн нь өмнөх оны жилийн эцсийн дүнгээс 11 хувиар буюу 5,654 ширхэг хувьцаагаар буурсан байна.

Б. МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГЫН 2012 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ:

2012 оны 3 дугаар улирлын байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагын актив, пассивын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал дараахь байдалтай байна:

Нийт 78 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн 2012 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдсан бөгөөд уг нэгтгэлээр мэргэжлийн оролцогч байгууллагуудын нийт активын хэмжээ 2,408.3 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны мөн үетэй харьцуулахад даруй 2310.3 тэрбум төгрөгөөр буюу 23.6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Үүний үндсэн шалтгаан нь хөрөнгийн зах зээлд арилжааны банк өөрөө болон түүний охин компаниуд Банкны тухай хуулийн 6.2.5, 6.2.4-д зааснаар харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ эрхлэх болон андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, 2011 онд хөрөнгийн зах зээлд хандах иргэдийн сонирхол идэвхжиж, Хорооноос брокер, дилерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдсэн зэрэг бөгөөд үр дүнд нь салбарын нийт активын дүн эрс өсчээ.

Тодруулбал, 2011 онд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан “Голомт банк” ХХК-ийн нийт хөрөнгө салбарын нийт активын дүнгийн 96,0 хувийг дангаараа эзэлж байна. Үүний үр дүнд салбарын нийт актив, пассив болон орлого, үр дүнгийн бүх үзүүлэлтэд “Голомт” банкны санхүүгийн үзүүлэлтүүд давхар нөлөөлж, ингэснээр бодит бус өсөлтийг харуулж байна. Ялангуяа банкны үйл ажиллагааны үзүүлэлтээс мэргэжлийн оролцогч байгууллагуудын орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлтийг салгаж харуулах ямар нэг боломж байхгүй байгаа нь эргээд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулсны орлого салбарын хэмжээнд хэд дахин нэмэгдсэн, зах зээл үсрэнгүй хөгжиж байгаа мэт буруу ойлголтыг төрүүлэхээр байна.

Салбарын хэмжээгээр нийт хөрөнгийн 99 хувийг хүснэгтэд буй доорхи 14 мэргэжлийн оролцогч компани бүрдүүлжээ. Үүнд:

Хүснэгт-12

№	Мэргэжлийн оролцогч байгууллага	Нийт хөрөнгө
1	Голомт банк ХХК/андеррайтер/	2,312,243,203,187.77
2	ҮЦТТГХТ ХХК	40,781,833,294.43
3	Ти Ди Би Капитал ХХК	8,646,409,958.28
4	Би Ди Сек ХК	11,009,830,961.89
5	Монголын хөрөнгийн бирж ХК	796,345,463.06
6	Нортенсек	3,137,803,733.87
7	Юнайтэд секьюритс	4,835,041,119.01
8	Фронттиер	1,979,950,932.64
9	Эм Ай Си Си	939,107,825.40
10	Туушин Инвест	447,835,484.88
11	Гаули	598,139,267.30
12	Евроази капитал монголиа	1,585,842,910.86
13	Монет капитал	479,443,393.0
14	Эс Жи Капитал	597,980,345.86

Нийт дүн	2,388,079,767,878.25
Салбарын нийт хөрөнгийн дүн	2,408,354,990,287.77

Нийт активын дүнд эргэлтийн хөрөнгийн дүн 97 хувь, эргэлтийн бус хөрөнгийн дүн 3.0 хувийг тус тус эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгийн дүн 26.4 дахин, эргэлтийн бус хөрөнгийн дүн 5.6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Эргэлтийн хөрөнгийн бүтцээр нь задалж үзвэл, энэхүү дүнг мөнгөн хөрөнгө 29.2 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 8.1 хувь, авлага 60.7 хувь, бараа материал 0.2 хувь, урьдчилж төлсөн зардал 0.6 хувь, бусад хөрөнгө 1.2 хувиар тус тус бүрдүүлжээ.

Эргэлтийн бус хөрөнгийн дүнг 2011 оны мөн үетэй харьцуулахад даруй 41.1 тэрбум төгрөгөөр буюу 5.8 дахин өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгө 83.5 хувь, бусад үндсэн хөрөнгө 1.3 хувь, биет бус хөрөнгө 3.2 хувь, бусад хөрөнгө 12 хувиар тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт-13

Балансын хураангуй	2012/03	2011/03	Өөрчлөлт
Нийт хөрөнгө	2,408,354,990,287.77	98,016,984,838.34	2,310,338,005,449.43
Эргэлтийн хөрөнгө	2,358,611,438,817.98	89,385,204,176.92	2,269,226,234,641.06
Эргэлтийн бус хөрөнгө	49,743,551,469.79	8,631,780,661.42	41,111,770,808.37
Өр төлбөр	2,132,271,231,360.50	49,342,722,783.90	2,082,928,508,576.60
Богино хугацаат өр төлбөр	2,019,871,588,011.42	42,694,984,810.73	1,977,176,603,200.69
Урт хугацаат өр төлбөр	112,399,643,349.08	6,647,737,973.17	105,751,905,375.91
Эзэмшигчдийн өмч	276,083,758,593.28	48,674,262,054.44	227,409,496,538.84
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	2,408,354,990,287.77	98,016,984,838.34	2,310,338,005,449.43

2012 оны 3 дугаар улирлын нийт пассивын дүнд өр төлбөрийн дүн 88.5 хувь, эзэмшигчийн өмчийн дүн 11.5 хувийг тус тус эзэлж байна. Өр төлбөрийн нийт дүнд богино хугацаат өр төлбөр 94.72 хувийг, урт хугацаат өр төлбөр 5.28 хувийг тус тус эзэлжээ.

Нийт салбарын активын хэмжээ 2,408.3 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарын нийт активын дүнгээс даруй 24 дахин, хадгаламж зээлийн салбарын нийт активын дүнгээс даруй 36.8 дахин, банк бус санхүүгийн байгууллагын нийт активын дүнгээс даруй 9.8 дахин өндөр үзүүлэлттэй байна.

2012 оны 3 дугаар улирлын мэргэжлийн оролцогч байгууллагын орлого, үр дүнгийн тайлангийн нэгтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал дараахь байдалтай байна:

Тайлант хугацааны эцсээр үндсэн үйл ажиллагааны орлого **190.7** тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 130.1 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин өсчээ.

2012 оны 3 дугаар улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны нийт орлогын 98 хувийг “Голомт банк” ХХК/андеррайтер/, “Би Ди Сек” ХК, “МХБ” ХК, “Ти Ди Би” ХХК, “ҮЦТТТХТ” ХХК, “Эм Ай Си Си” ХХК, “Фронттиер” ХХК, “Евразиа капитал монголиа” ХХК, “Эс Жи Капитал” ХХК, “Монет капитал” ХХК зэрэг 10 компани бүрдүүлсэн бөгөөд салбарын хэмжээнд нийт 21 компани ашигтай ажилласан боловч нийт 54 компани алдагдалтай ажиллажээ.

Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын дийлэнхи нь алдагдалтай ажиллаж буйн шалтгаан нь салбарын өсөлтийг дэмжихүйц хууль тогтоомжийн тогтолцоо бүрэлдээгүй, зах зээлийн бүтээгдхүүн, үйлчилгээний сонголт хомс, үнэт цаасаар

хөрөнгө татан төвлөрүүлэх зах зээлийн багтаамж бага, зах зээлд боломжит хэмжээнд шинэ бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэхгүйд байна. Энэ нь эргээд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхол эрс буурахад нөлөөлж байна. Мөн мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн чадвар хангалттай бус, иргэдийн идэвхи оролцоо /ХОЭБ-ээр хувьцаа эзэмшсэн иргэдийн багагүй хувь нь дансаа нээлгээгүй, тэр хэмжээний хувьцаа эргэлтэд оролгүй түгжигдсэн/, санхүүгийн чадамж сул, зөвхөн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг учраас банкууд болон бусад аж ахуйн нэгжүүдтэй өрсөлдөх чадвар сул, мөн андеррайтерийн компаниуд санхүүгийн эх үүсвэр хайж буй аж ахуй нэгжүүдэд хөрөнгийн зах зээлээс хямд өртгөөр хөрөнгө татан төвлөрүүлэх боломжийг таниулан, хамтран ажиллах тал дээр хангалтгүй ажилласан зэргийг дурьдах нь зүйтэй.

Хөрөнгө оруулагч нараас хөрөнгө оруулалтын эх үүсвэр татаж хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг бий болгодог үндсэн хүчин зүйлүүд болох төлбөр тооцооны техник, технологийн цогц дэд бүтэц бүрэлдээгүй, шинэ системийн жигдрэлт удааширсан, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах институци болох кастодианы зохицуулалт хэрэгжээгүй, нийт хувьцааны 70-аас дээш хувь нь нэгдмэл сонирхолтой этгээдийн гарт төвлөрсөн хувьцаат компанийг үнэт цаасны бүртгэлээс хасах талаар дорвитой ажил зохиогдоогүй, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс зохицуулагч байгууллагаас conglomerates аж ахуй нэгжүүдийн нэгдсэн хяналтыг бий болгох бодлого баримтлаагүй, уг хяналтыг нэг байгууллага хянан зохицуулах эрх зүйн боломж бүрдээгүй зэрэг нь зах зээлийн хөгжилд тодорхой нөлөө үзүүлжээ.

Гадаад болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчын тоог нэмэгдүүлж, зах зээлийн хөрвөх чадвар, багтаамжийг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх хамтын хөрөнгө оруулалтын байгууллага буюу хөрөнгө оруулалтын сан мөн зохицуулалтын байгууллагын хяналт дор үйл ажиллагаа явуулдаг, хөрөнгө оруулалтыг гэрээгээр удирдан мэргэжлийн түвшинд хэрэгжүүлдэг байгууллагын орон зай үгүйлэгдэж байна. Ялангуяа, институциональ сангууд нь тус тусдаа мэргэжлийн багийг байнга ажиллуулах санхүүгийн боломж хязгаарлагдмал, нөгөө талаас ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай тул тусгайлан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байх нь зохистой боловч өнөөдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх хуулийн этгээд байхгүй байгаа билээ.

Мөн дээр өгүүлснээр “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр шинэ систем нэвтрүүлэх, Т+3 буюу үнэт цаасны төлбөр тооцооны шинэ горимд шилжих бэлтгэл ажлын хүрээнд 3 төрлийн сангуудад одоогийн байдлаар нийт 1 тэрбум 438 сая төгрөгийг эрсдлийг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн нь тэдгээрт санхүүгийн дарамт болсон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын бүтцийг үйл ажиллагааны орлого 4.5 хувь, хөрөнгө оруулалтын орлого 78.4 хувь, борлуулалтын бусад орлого 17.1 хувиар тус тус бүрдүүлж байна.

Нийт ашиг 189.1 тэрбум төгрөг, нийт үйл ажиллагааны зардал 157.0 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт салбарын хэмжээнд 25.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 7.3 тэрбум төгрөгийн орлогын татвар төлжээ. Нийт салбарын хэмжээнд цэвэр ашгийн 99 хувийг “Голомт банк” ХХК /андеррайтер/, “Би Ди Сек” ХК, “ҮЦТТТХТ” ХХК, “Ти Ди Би Капитал”, “МХБ” ХК, зэрэг 5 компани бүрдүүлснээс Голомт банк ХХК дангаараа 93 хувийг /24,223,319,354.14 төгрөг/ эзэлж байна.

Хүснэгт-14

2012 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ	ДҮН
Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	190,738,375,430.14
Үйл ажиллагааны орлого	8,538,800,722.27
Брокер, дилерийн үйл ажиллагааны	6,649,142,150.22

Андеррайтерийн үйл ажиллагааны	1,082,799,022.47
Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний	806,859,549.58
Хөрөнгө оруулалтын орлого	149,517,562,009.47
Хүүгийн орлого	124,366,074,698.68
Арилжаалсан үнэт цаасны орлого	25,141,698,204.47
Ноогдол ашгийн орлого	9,789,106.32
Бусад	32,682,012,698.40
Борлуулалтын хөнгөлөлт	90,465.75
Борлуулалтын хорогдол ба буцаалт	1,202,080.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр борлуулалтын орлогын дүн	190,737,082,884.39
Борлуулсан үнэт цаасны өртөг	1,612,971,340.59
Нийт ашиг (алдагдал)	189,124,111,543.80
Үйл ажиллагаа (борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	155,725,109,307.11
Үндсэн болон нэмэгдэл цалин	14,437,928,816.58
Нийгмийн даатгалын шимтгэл	1,470,918,061.76
Засвар үйлчилгээний зардал	142,466,410.77
Ашиглалтын зардал	367,944,978.70
Түрээсийн зардал	4,113,084,867.05
Албан томилолтын зардал	1,142,354,740.77
Тээврийн зардал	14,615,977.00
Түүхий эд материалын зардал	843,224,978.44
Элэгдлийн зардал	3,685,631,515.00
Зар сурталчилгааны зардал	1,463,305,789.49
Шуудан холбооны зардал	770,015,713.64
Шатхууны зардал	723,939,524.75
Найдваргүй авлагын зардал	8,713,774,310.15
Шагнал урамшууллын зардал	290,790,313.90
Зээлийн хүүгийн зардал	102,425,092,028.40
Зохицуулах хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс	40,891,298.20
Биржийн гишүүн хураамж	1,162,648,473.81
ҮЦТТХТ-ийн үйлчилгээний хураамж	2,406,299,071.07
Шимтгэл	1,804,596,178.76
Зохицуулалтын үйлчилгээний хураамж	233,155,206.97
Хөрөнгийн биржийн шимтгэл	813,274,554.25
ҮЦТТХТ-ийн шимтгэл	758,166,417.54
Бусад зардал	9,705,586,258.88
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	33,399,002,236.69
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-138,703,882.27
Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг, алдагдал	-80,988,404.40
Торгууль, хөнгөлөлт ашиг (алдагдал)	61,665,685.27
Эрсдлийн сангийн зардал	-126,210.00
Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал)	18,717,598.28
Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг (алдагдал)	51,612,810.63
Хувьцаа, бондын зардлын хорогдуулга	-12,061,392.84
Хараат болон хамтарсан үйлдвэрээс олсон ашиг	#N/A
Бусад	-177,523,969.21
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	33,260,298,354.42
Орлогын татварын зардал	7,394,653,339.86

Татварын дараах ашиг (алдагдал)	25,865,645,014.56
Цөөнхөд ноогдох хувь	
Ердийн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	25,865,645,014.56
Онцгой шинжтэй зүйл – цэвэр	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	25,865,645,014.56
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	

Олон улсын санхүүгийн менежментийн капиталын бүтцийн ерөнхий загваруудыг үзэхэд аливаа компани богино хугацаат эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг банкны зээл болон бусад богино хугацаат эх үүсвэрээр бүрдүүлдэг бол урт хугацааны хөрөнгө оруулалтыг хийхэд шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийг голчлон хөрөнгийн зах зээлээс IPO, SPO, хийх замаар болон урт хугацаат санхүүжилтийн бусад эх үүсвэр болох өрийн бичгийг гаргах аргаар шийдвэрлэдэг билээ.

Олон улсын санхүүгийн зах зээлд тоглогч институциональ хөрөнгө оруулагчдын нийтлэг сонирхол нь эрсдэл бага өндөр өгөөжтэй үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийхэд анхаарал хандуулж шинэ тутам хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулах сонирхол өндөр байдаг. Энэ утгаараа санхүүгийн зах зээлийн томоохон тоглогчдыг татах, тэдний сонирхолыг идэвхжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ авах нь зохицуулах байгууллагын үндсэн үүрэг юм.

Монгол Улсын өнөөгийн санхүүгийн зах зээлийн зохицуулалтын бүтцийг харахад нийт санхүүгийн салбарын 4.4 хувийг Санхүүгийн зохицуулах хороо, үлдсэн 95.6 хувийг Монгол банк дангаараа зохицуулж байна. Монгол улсад банкны салбар хэт давамгайлсан энэ байдал нь ирээдүйд банкны салбарт үүссэн хүндрэл санхүүгийн секторт нөлөө үзүүлэх үр дагавартай тул санхүүгийн секторын хөгжлийг сааруулах, цаашилбал хямралд хүргэх аюултай. Иймд банкнаас бусад салбарын өсөлтийг дэмжихүйц хууль, эрх зүйн тогтолцоог бодлогоор сайжруулах, бүрдүүлэх шаардлагатай байна. Хавсралт 1-ээс үзнэ үү.

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн оролцогчдыг зөвхөн бие даасан банк, даатгал, брокер, дилер, банк бус санхүүгийн байгууллагаас бүрдэж байгаа гэвэл өрөөсгөл бөгөөд санхүүгийн салбарын холимог оролцогч болох conglomerates аж ахуй нэгжүүд зах зээлд нэгэнт бий болж, Хорооны зохицуултад хамрагдаж байна.

Энэ утгаараа эдгээр аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавьж чадах зохицуулалтын тогтолцоо нэн тэргүүнд шаардлагатай бөгөөд үүнээс шалтгаалан санхүүгийн зах зээлийн хөгжил, тэдгээрийн зах зээлийн идэвх, хөрөнгө оруулагчдын хандлага, үр ашиг хамаардаг.

Олон улсын туршлагаас харахад нэгдсэн хяналт шалгалтын гурван хандлага бүхий загвар байдаг ба товчхон дурьдвал Америкийн загвар (Multiple supervisors model), Мексик, Канад, Өмнөд Африкийн загвар (Partially unified supervisors model), Англи, Сингапурын загвар (Single supervisor model) зэрэг юм. Хавсралт 2-оос үзнэ үү.

Монгол Улсын санхүүгийн зах зээлд conglomerates аж ахуй нэгжүүд нэгэнт бий болж, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны харилцааг гүйцэтгэх, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны өмчлөх эрхийг баталгаажуулж, тэдний эрхийг хамгаалагч институт болох кастодиан банк, харилцагчийн нэрийн өмнөөс түүнийн даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын үйлчилгээ болон андеррайтерийн үйлчилгээг арилжааны банкууд өөрөө болон өөрийн охин, хараат компаниар дамжуулан гүйцэтгэж болох манай өнөөгийн нөхцөлд Англи, Сингапурын загвар (Single supervisor model)-аар зохицуулалтын байгууллагын бүтцийг боловсруулж, нэгдсэн хяналтыг тодорхой нэг байгууллага хэрэгжүүлэх нь хамгийн тохиромжтой хувилбар бөгөөд үүний зэрэгцээ өөрөө өөрийгөө зохицуулагч байгууллагын эрх зүйн чадамжийг дээшлүүлэх шаардлагатай байна.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА

2011 оны жилийн эцсийн байдлаар

Үзүүлэлтүүд	Банкны салбар	Даатгалын салбар	Мэргэжлийн оролцогч	Банк бус санхүүгийн байгууллага	Хадгаламж зээлийн хоршоо	СЗХ-ны зохицуулалтын салбарын нэгдсэн дүн	Нийт санхүүгийн салбарын дүн	Нийт санхүүгийн салбарт эзлэх хувь
Нийт актив	9,371,628,345,400.00	81,233,460,041.32	67,591,829,900.90	205,409,535,100.00	61,899,296,740.78	416,134,121,783.00	9,787,762,467,183.00	4.4
Банкны салбарт эзлэх хувь	100.00	0.87	0.72	2.19	0.66	4.44		
Дүрмийн сан /ХНХ/	270,144,329,740.00	26,781,684,150.81	24,626,059,859.91	116,519,924,000	8,356,913,962.30	176,284,581,973.02	446,428,911,713.02	39.5
Банкны салбарт эзлэх хувь	100.00	9.91	9.12	43	3.09	65.26		
Өөрийн хөрөнгө	676,895,154,200.00	40,139,982,745.34	39,174,513,994.25	138,182,359,600.00	13,190,107,830.13	230,686,964,169.72	907,582,118,369.72	25.4
Банкны салбарт эзлэх хувь	100	5.93	5.79	20.41	1.95	34.1		

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА

2012 оны 3 дугаар улирлын байдлаар

Үзүүлэлтүүд	Банкны салбар	Даатгалын салбар	Мэргэжлийн оролцогч	Банк бус санхүүгийн байгууллага	Хадгаламж зээлийн хоршоо	СЗХ-ны зохицуулалтын салбарын нэгдсэн дүн	Нийт санхүүгийн салбарын дүн	Нийт санхүүгийн салбарт эзлэх хувь
Нийт актив	10,927,102,708,600.00	100,801,031,740.50	96,111,787,100.81	245,386,298,800.00	65,450,973,400.00	507,750,091,041.31	11,434,852,799,641.30	4.4
Банкны салбарт эзлэх хувь	100.00	0.92	0.88	2.25	0.60	4.65		
Дүрмийн сан /ХНХ/	296,869,413,790.00	34,341,684,150.81	25,339,253,882.78	133,289,227,100.00	8,920,341,400.00	201,890,506,533.59	498,759,920,323.59	40.5
Банкны салбарт эзлэх хувь	100.00	11.57	8.54	45	3.00	68.01		
Өөрийн хөрөнгө	922,711,428,750.00	49,399,455,063.08	42,771,355,623.93	162,240,121,300.00	15,154,492,600.00	269,565,424,587.01	1,192,276,853,337.01	22.6
Банкны салбарт эзлэх хувь	100.00	5.35	4.64	17.58	1.64	29.2		

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Нэгдсэн хяналтын тогтолцоо /Single supervisor/		Хэсэгчилсэн хяналт тогтолцоо /Partially unified supervisors/			Төрөлжсөн хяналтын тогтолцоо /Multiple supervisors/	
		Банк ба үнэт цаас	Банк ба даатгал	Банк бус бүгд		
Австри	Казахстан	Ливан	Канад	Боливи	Албани	Шинэ Зеланд
Бельги	Өмнөд солонгос	Мексик	Колумби	Болгар	Алжир	Нигери
Бермуд	Латви		Эквадор	Чили	Аргентин	Панам
Чех	Мальт		Сальвадор	Хорват	Багам	Филиппин
Эстони	Никарагуа		Гондурас	Ямайка	Барбадос	Португал
Япон	Норвеги		Малайз	Намиби	Бразил	Румын
Финлянди	Польш		Голланд	Пакистан	Хятад	ОХУ
Гүрж	Сингапур		Парагвай	ӨАБНУ	Доминикан	Словени
Герман	Словак		Перу		Египт	Испани
Гибралтар	Швед		Саудын Араб		Франц	Шри Ланка
Гватемал	Швейцар		Венесуэл		Грек	Танзани
Унгар	Тайван				ХонКонг	Тайланд
Исланд	Англи				Энэтхэг	Тунис
Ирланд	Уругвай				Индонези	Турк
					Израйль	Уганда
					Итали	Украин
					Иордани	Эмират
					Кени	АНУ
					Литва	Люксембург
					Морокко	
29 /32%/		21 /23%/			36 /43%/	